



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А166

Улаанбаатар хот

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг
ханган ажиллах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 1а/804 дугаар албан бичгийг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор ТУШААХ НЬ:

1. Эдийн засагч Саандарын Алтаннамар өөр ажилд шилжсэнтэйгээр холбогдуулан Шилэн дансын тухай хууль, Засгийн Газраас баталсан тогтоол, тушаалыг СЭМҮТ-ийн үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлэн ажиллахыг Санхүү бүртгэлийн албаны нягтлан бодогч /Э.Гэрэлмаа, Ц.Хэрлэнцэцэг/, программист /П.Энхтуяа/ нарт үүрэг болгосугай.


2. Шилэн дансны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, журам, тушаалуудыг нэг бүрчлэн судлаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, Эрүүл мэндийн сайдаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тусгасан 2017 онд хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөөг дахин шинэчлэн гарган батлуулж, холбогдох албан тушаалтнуудад үүрэг хариуцлагыг танилцуулж, мөрдөн ажиллахыг нягтлан бодогч /Э.Гэрэлмаа, Ц.Хэрлэнцэцэг/, программист /П.Энхтуяа/ нарт үүрэг болгосугай.

3. Мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллуулахыг Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, мэдээллийн технологи эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/, Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энхжаргал/ нарт үүрэг болгосугай.

4. Шилэн дансны тухай хууль, холбогдох тогтоол, шийдвэрүүдийг тогтоосон хугацаанд нь хариуцлагатай биелүүлж, ямар нэгэн гомдол чирэгдэлгүй хуулийн хугацааг баримтлан ажилласан тохиолдолд нягтлан бодогч /Э.Гэрэлмаа/, программист /П.Энхтуяа/ нарт ажлын гүйцэтгэлийг дүгнэж улирал тутам үндсэн цалингийн 30 /гуч/ хүртэл хувиар урамшуулах, хариуцлага алдсан тохиолдолд

шалтгаан нөхцөлийг тодруулж, гэм буруутай албан тушаалтныг Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 заалтын дагуу Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, сахилгын шийтгэл ноогдуулж ажиллахыг Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, мэдээллийн технологи эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ